

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

1. Хүмүүс хэрэгцээгээ хангах, зөрчил маргаан, эмх замбараагүй байдалд хүргэхгүйн тулд үүргээ хуваарилан зохион байгуулалтад орж, хянаж, зохицуулах замаар амьдарч буй хамтын амьдралын хэлбэрийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 A. Нийгэм B. Нийгмийн тогтолцоо C. Нийгмийн байр суурь
 D. Нийгмийн бүтэц E. Нийгмийн харилцаа
2. “Марксын үзэл санаанд тулгуурлан, М.Веберийн үзэл санааг харгалзан нийгмийн давхраажилтыг судалсан судлаач аль нь вэ? /1 оноо/
 A. Т.Парсонс B. Е.О.Райт C. Э.Дюркгейм D. Л.Уорнер E. Дэвис ба Мур
3. Нийгмийн давхраажилтын эрх мэдлийн хэмжигдэхүүнд хамаарах ойлголтуудыг сонгоно уу. /2 оноо/

- | | |
|------------------------------|---|
| 1. Онцгой авьяас чадвар | 2. Шийдвэр гаргах |
| 3. Бусдад нөлөөлөх, дагуулах | 4. Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, үнэ цэн |
| 5. Олон танигдсан байдал | 6. Нөөцийг ашиглах, хуваарилахад хяналт тавих |

- A. 3, 4, 5 B. 1, 3, 5 C. 2, 3, 6 D. 3, 5, 6 E. 1, 4, 5

4. Нийгмийн давхраажилтын хэв маягуудын нэг болох “Анги”-н тухай ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б	В
1-р хэсэг	Хувийн байр сууриа өөрчлөх боломжтой	Нээлттэй нийгэмд харьяалагддаг	Дундад зууны үед ноёрхож байсан
2-р хэсэг	Ажил мэргэжлээр ялгагдах	Давхраа харгалзахгүйгээр гэрлэх нь харьцангуй нээлттэй	Эдийн баялагаар ялгаатай

- A. 1-р хэсэг – В; 2-р хэсэг –Б
 B. 1-р хэсэг – В; 2-р хэсэг –А
 C. 2-р хэсэг – А; 1-р хэсэг –Б
 D. 1-р хэсэг – А; 2-р хэсэг –А
 E. 2-р хэсэг – А; 2-р хэсэг –В

5. Монголын нийгэм нь олон давхраанаас бүрдэж байв. Дээд хэсэг нь хошууны ноёд, тайж, лам нар, дунд давхрааг жирийн малчин ард, доод давхраанд гэрийн боолчууд байсан. Энэ нь монголын түүхийн аль хэсэгт хамаарах вэ? /1 оноо/
 A. XII-XIV зуунд B. Юань улсаас хойш
 C. Социализмын үе D. Манжийн эрхшээлийн үе E. Их Монгол улсын үед



6. Дараах ойлголтуудаас чанарын судалгаанд аль нь хамаарах вэ?

/1 оноо/

1. Стандарчлагдсан загварын дагуу үр дүнг нэгтгэн бичнэ.
2. Таамаглалыг шалгахад зорино.
3. Цөөн тооны хувьсагч хоорондын хамаарлыг шалгахад анхаарна.
4. Стандарчлагдсан загварын дагуу үр дүнг бичих албагүй.
5. Хэмжилт нь мэдээлэл цуглуулах явцад эсвэл дараа нь хийгдэнэ.

A. 1, 4 B. 2, 5 C. 2, 4 D. 3, 4 E. 4, 5

7. Индукцийн аргын тухай дараах өгөгдлүүдийг ажиглаад зөв эрэмбэд оруулна уу. /2 оноо/
 Өгөгдөл: /**a**-онол, **b**-асуулт, **c**-нэгтгэн дүгнэх, **d**-туршилт буюу дүн шинжилгээ, **e**-ажиглалт буюу мэдээлэл цуглуулалт/



A. 1b2d3e4a5c B. 1b2e3d4a5c C. 1a2b3e4d5c D. 1e2d3b4a5c E. 1b2e3d4c5a

8. Дараах хүснэгтэд байгаа нийгмийн хэв маягуудыг ажиглаад аль нийгмийн хэв маягийн хэд дүгээр баганад алдаа байгааг тодорхойлно уу. /2 оноо/

Нийгмийн хэв маяг	1-р багана	2-р багана	3-р багана
Ан агнуурын нийгэм	Эдүгээ Австралийн уугуул иргэд ийм төрлийн нийгмийн байгуулал бүхий байсаар байна.	Нүүдэллэн амьдардаг нийгэм бөгөөд улс төрийн бүтэц үгүй	Чулуу, сүх, жад, хутга зэрэг энгийн зэвсэг ашигладаг.
Цэцэрлэг аж ахуйн нийгэм	НТӨ 4000 он тэртээ үүсэж Ази, Европ даяар тархсан	Ураг төрлийн холбоонд суурилсан олон төрлийн овгуудаас тогтох нийгэм	Тариалангийн аж ахуйд анжис ашиглаж эхэлсэн.
Газар тариалангийн нийгэм	Анх эртний Египетэд үүссэн бөгөөд түүхэнд хамгийн бага тархсан	Ураг төрлийн холбоонд тулгуурлахаа больж, өрх гэр бүлд суурилсан эдийн засгийн харилцаа үүссэн.	Төр үүсэж, бичиг үсэг хэрэглэх болж, мөнгөн гүйлгээ ашиглах болсон.
Аж үйлдвэржсэн нийгэм	Их Британи дахь аж үйлдвэржилтийн нөлөөгөөр XVIII зууны сүүлчээр үүссэн	Төвлөрөн суурьшсан хотын маш олон хүн амын хэрэгцээг хангах болсон.	Төрийн удирдлага нь бюрократ байгууллагын тогтолцоонд суурилсан

- A. Ан агнуурын нийгмийн 1-р багана
 Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 3-р багана
 C. Газар тариалангийн нийгмийн 2-р багана
 Аж үйлдвэржсэн нийгмийн 1-р багана
 E. Ан агнуурын нийгмийн 2-р багана
 Газар тариалангийн нийгмийн 1-р багана
- B. Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 3-р багана
 Газар тариалангийн нийгмийн 1-р багана
 D. Газар тариалангийн нийгмийн 3-р багана
 Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 2-р багана



9. Т.Билтон нарын тодорхойлсон “Уламжлалт буюу аж үйлдвэржилтээс өмнөх үе”-ийн нийгмийн шинжүүдэд хамаарахыг олооорой. /2 оноо/

Орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгэм	1	Шинжлэх ухааны итгэл үнэмшлийн тогтолцоо тэргүүлэх үүрэгтэй
	2	Хувийн хүсэл зориг гэхээсээ нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэн хувь хүн амьдардаг.
	3	Хүний амьдралын үйл ажиллагааны гол талбар нь өрх гэр, гэр бүлийн хүрээ байна.
	4	Нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэх гэхээсээ хувийн хүсэл зоригийг хэрэгжүүлэхийг эрхэмлэдэг.
	5	Олон нийтийн байгууллагын хүрээнд олон янзын үүрэг хүлээж, олон талт харилцаа бүхий байна.

- A. 2, 5 B. 3, 4 C. 1, 5 D. 2, 3 E. 2, 4

10. Зөгий, шоргоолжны эд эсэнд нь шингэсэн үйлдэл хийх чадвар байдаг шиг хүнд төрөлхөөс заяадаггүй, ахмад үеэсээ залуу үе нь зориуд сурч мэдэж, өвлөх ёстой үйлдэл хийх чадвар байдгийг соёл гэж тэмдэглэдэг. Үүнийг дараах эрдэмтдийн аль нь үзсэн бэ? /1 оноо/
- A. Р.Бенедикт B. Э.Кассирер C. Э.Тайлор D. А.Гидденс E. Ж. Локк

Тохиолдлыг уншаад 11-13 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Бэк-Хён, Чан-Ёол, Ха-Кун, Ин-Су, Кижэ, Минжүн нар Солонгос улсаас монгол улсыг зорин аялахаар иржээ. Энэхүү аялал нь зүгээр ч нэг аялал биш харин монгол улсын соёл, түүний үүсэл хөгжил болон соёлын үйлдвэрлэлийн тухай судлахаар ирсэн соёл судлаачид юм. Мэдээж Бэк-Хён, Чан-Ёол, Ха-Кун, Ин-Су, Кижэ, Минжүн нар Монгол улсаар аялахдаа монгол улсын соёлын тухай мэдээлэл цуглуулж, судалгаа хийх тус тусын чиг үүрэгтэй ирсэн билээ. Тухайлбал:

- Бэк-Хён бол монгол хүмүүсийн зан төлөв, зан чанар болон шашны тухай,
- Чан-Ёол бол олон улсын соёл, барууны соёл, монголын соёлын тухай,
- Ха-Кун бол монголын социализмын үеийн соёлын тухай,
- Ин-Су бол монголын соёлын эртний, дундад зуун, орчин үеийн соёлын тухай,
- Кижэ бол монголын соёлын статик, динамик үзэгдлийн тухай,
- Минжүн бол монголын оюуны болон биет соёлын тухай тус тус судлахаар болжээ.

11. Солонгосын соёл судлаачдын тус бүрийн чиг үүрэг нь соёлын ямар шалгуурыг илэрхийлж байгааг зөв харгалзуулна уу? /1 оноо/

а) Соёлын нийгмийн хэв маягийн тухай б) Соёлын бүтээгч, хэрэглэгчийн тухай с) Соёлын суурь үнэлэмжүүдийн тухай д) Хүмүүсийн сонголт хийх боломжийн тухай	1	Судлаач Бэк-Хён
	2	Судлаач Чан-Ёол
	3	Судлаач Ха-Кун
	4	Судлаач Ин-Су
	5	Судлаач Кижэ
	6	Судлаач Минжүн

- A. a2b6c1d4 B. a4b5c1d6 C. a4b2c1d3 D. a2b5c1d3 E. a4b1c6d2

12. Дээрх тохиолдолд харуулж буй дүрслэлийг аль нь бүрэн илэрхийлж байна вэ? /1 оноо/
- A. Монголын соёлын ангилал болон судалгаа хийж байгаа аялагчдын тухай
B. Соёлын үйлдвэрлэл, аялал жуулчлал, соёлын ангилал, шалгуурын тухай
C. Соёлын үйлдвэрлэл болон соёлын аялал жуулчлалын зарчмын тухай
D. Соёлын аялал жуулчлал болон соёлын эрх чөлөөний суурь зарчмын тухай
E. Соёлын үйлдвэрлэл, соёлын орон зай, эрх чөлөөний суурь зарчмын тухай



13. Дээрх тохиолдолд соёлын үйлдвэрлэл болон аялал жуулчлал нь юунд тулгуурлан хөгжиж байгааг тодорхойлно уу? /1 оноо/

- A. Монгол улсын үүсэл хөгжил, соёлын үйлдвэрлэл болон судлаачдын эрэлт хэрэгцээнд түшиглэн хөгжиж байна.
- B. Монгол улсын соёлын аялал жуулчлалд баримталдаг зарчим болон соёлын аялал жуулчлалын төрөлд түшиглэн хөгжиж байна.
- C. Соёлын үйлдвэрлэл болон аялал жуулчлалын ач холбогдолд түшиглэн хөгжиж байгааг харуулж байна.
- D. Монгол улсын 2015 онд батлагдсан “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрт түшиглэн хөгжиж байна.
- E. Соёлын даяаршил болон соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрт тулгуурлан түшиглэн хөгжиж байна.

14. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /2 оноо/


Хүснэгт дэх жишээг ажиглаад соёлын харилцан үйлчлэлийн аль хэлбэр дутуу байгааг өгөгдсөн жишээнүүдээс сонгоорой.

Соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрүүд	
	Нэг хэсэг хүн амын соёлын амьдрал нөгөө хэсгийнхтэй адилсан, өмнөх соёлоосоо илүүд үзэх үр дүн юм.
	1930, 1940-өөд оны үед манай улс уламжлалт шашин, соёл, үндэсний бичиг зэргээ орхиход хүрсэн

- A. Тулга 85 настай бөгөөд түүний аав нь халх, ээж нь буриад хүн байсан. Тулга халх болон буриад гэр бүлийн уламжлал, ёс заншлыг мөн чанарыг ойлгосон нэгэн бөгөөд тэрхүү соёлоо үр хүүхдүүддээ зааж сургаж ирсэн.
- B. Дорж Сүхбаатар аймгийн Дарьганга сумын өндөрлөг тэгш газарт 200 орчим унтарсан галт уул байдаг тухай мэдээлэл гадаад, дотоодын аялагчдад хүргэж, соёлын үнэт зүйлсээ хамгаалж ирсэн.
- C. Ассир, Вавилон нь зэрэгцэн оршиж байсан ба оршин буй цаг хугацаандаа аль нэг улс нь хүчирхэг болох үедээ нөгөө улсаа эрхшээлдээ оруулдаг байв.
- D. Бүтээсэн бүхнийг устгаж, хүнийг тэр зүйлээ дахин бүтээхгүй болтол нь айлган сүрдүүлэх үйл явц
- E. Япон улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд “Монгол-Японы соёлын өвийн форум” зохион байгуулагдсан.

15. Дараах тохиолдлыг уншаад соёлын цочирдлын “Харь соёлд дасан зохицох үе шат”-ын аль үе шат дээр явж буйг тодорхойлоорой. /2 оноо/

График №1 /Харь соёлд дасан зохицох үе шат/



Тохиолдол

Боорчи ШУТИС -ийг 2024 онд төгссөн бөгөөд БНХАУ-д үргэлжлүүлэн суралцахаар болов. 2025 оны 3-р сард БНХАУ-д очоод тухайн улсын соёлд дасан боловч эргэн тойрныхоо хүмүүстэй харилцаа тогтоож чадахгүй байсан.


A. G-үе шат

B. E-үе шат

C. C-үе шат

D. F-үе шат

E. A-үе шат



16. “Монгол соёлыг нэгтгэгч язгуур үнэлэмжид монгол аж төрөх ёс, ардын урлаг, ёс заншил, бусад үндэстнээс ялгарсан өвөрмөц төрхтэй” гэсэн нь соёлын аль ойлголтыг илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. Түгээмэл шинж B. Соёлын релятивизм C. Сонгодог соёл
D. Нэгдмэл шинж E. Соёлын этноцентризм

17. Соёлынх нь өвөрмөц байдал болон бусдаас ялгаран онцгойрох хэв маягт гаднын нөлөө орж өөрчлөгдөх, эсвэл соёлын тулгалтаар устгах оролдлого гарах тохиолдол бүрд хариу үйлдэл үзүүлэх чадварыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Соёлын дархлаа B. Соёлын адилсал C. Соёлын эрх чөлөө
D. Соёлын даяаршил E. Соёлын үйлдвэрлэл

18. Логик гэдэг нь ямар үгнээс гаралтай вэ? /1 оноо/

- A. Грек хэлний syntaxes (холбох, нийлүүлэх, бүтэц) гэдэг үгнээс гаралтай.
B. Грек хэлний logos (үг ойлголт) гэдэг үгнээс гаралтай.
C. Грек хэлний understanding (мэдээлэл, мэдлэг) гэдэг үгнээс гаралтай.
D. Грек хэлний policy (төлөвлөлт, стратеги) гэдэг үгнээс гаралтай.
E. Грек хэлний topic (агуулга, яриа) гэдэг үгнээс гаралтай.


19. Хэлний тухай ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой. /1 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Хэлний үндсэн чиг үүргүүд гэдэг нь танин мэдэхүйн хийгээд харилцааны явцад хэлний шийдвэрлэж буй үндсэн зорилтууд юм.	Хэл бол хүмүүсийн өдөр тутмын харилцааны болон танин мэдэхүйн хэрэгсэл юм.
2-р хэсэг	Хэл бол хүний оюуны үйл ажиллагааны бүтээгдэхүүн, тэмдгэн мэдээллийн систем биш.	Хэлний тусламжтайгаар мэдлэг, чадвар, амьдралын туршлага нь нэг үеэс нөгөө үед дамжин уламжлагддаггүй.

- A. 1-р хэсэг – А; 2-р хэсэг - Б B. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – А; 2-р хэсэг - А D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг - Б
E. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

20. “Зарим амьтан бол өвсөн тэжээлтэн мөн” гэсэн бодомжийг аль бүдүүвч нь зөв илэрхийлж байна вэ? /1 оноо/

Жич: W – амьтан, Q – өвсөн тэжээлтэн



21. Инфляцийг бууруулах төрөөс авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа аль нь вэ? /1 оноо/

- A. Эдийн засгийн дотоод тэнцвэрийг алдагдуулна
B. Өндөр татвар хураах сонирхол бий болно
C. Бүтээгдэхүүний үнэ өснө
D. Бараа үйлчилгээний эрэлт муудна
E. Төсвийн алдагдлыг шийдвэрлэх




22. Чөлөөт эдийн засгийн тогтолцоонд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
- Үндсэн шинж нь хувийн өмч байдаг.
 - Техникийн дэвшил, хөрөнгө оруулалт хийх явдал хязгаарлагдмал.
 - Хоёрдогч шинж нь ашгийн хойноос хөөцөлддөг.
 - Үйлдвэрлэлийн хэрэгсэл нь хувь хүмүүсийн эзэмшилд байдаг.
 - Төрөөс эдийн засгийн үйл явц дахь оролцоо маш бага байдаг.

23. Дараах графикийг ажиглаад даалгаврыг гүйцэтгээрэй. /2 оноо/
- Дараах хөдөлмөрийн зах зээлийн графикийг анхааралтай ажиглаад асуултад хариулаарай.

$W(\text{wage})$ -цалин (1000 нэгж буюу 1000000 төгрөг)

$L(\text{Labor})$ -Хөдөлмөрийн тоо хэмжээ



Асуулт:

Ажиллах хүчний хомсдол бий болсон цалингийн түвшин, эрэлт, нийлүүлэлтийн хөдөлмөрийн тоо хэмжээг

Цалин	Хөдөлмөрийн нийлүүлэлт буюу ажил хайгчийн тоо хэмжээ	Хөдөлмөрийн эрэлт буюу ажиллах хүчний тоо хэмжээ
.....?	?	?

- Цалин-1800; ажил хайгчийн тоо хэмжээ-400; ажиллах хүчний тоо хэмжээ-300
 - Цалин-1800; ажил хайгчийн тоо хэмжээ-250; ажиллах хүчний тоо хэмжээ-450
 - Цалин-1800; ажил хайгчийн тоо хэмжээ-450; ажиллах хүчний тоо хэмжээ-250
 - Цалин-1800; ажил хайгчийн тоо хэмжээ-300; ажиллах хүчний тоо хэмжээ-400
 - Цалин-1800; ажил хайгчийн тоо хэмжээ-450; ажиллах хүчний тоо хэмжээ-400
24. Дараах ойлголтуудаас аль нь татвар хураалтын шударга байх зарчмыг илэрхийлж байна вэ? /1 оноо/
- Татварын хэмжээ болон татвар хураах аргыг урьдчилан мэдэгдсэн байх
 - Татварын хэмжээ, татвар хураах хугацааг урьдчилан мэдэгдсэн байх
 - Бүх хүн хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж
 - Завсрын ямар нэгэн шат дамжлага дамждаг(нэмэгдсэн өртгийн алба татвар)
 - Бүх нийтээр төлдөг, татвар нь хүмүүсийн орлоготой шууд хамааралтай байх
25. Хөрөнгийн зах зээлийн өөрчлөлт хөдөлгөөнийг хоёр амьтны ерөнхий шинж чанартай нь адилтгадаг. Тэгвэл хөрөнгийн зах зээл дээр хувьцаа худалдан авах эрэлт нэмэгдэж ингэснээр хувьцааны үнэ өсөхийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
- Bull market
 - Bear market
 - Tiger market
 - Wolf market
 - Crocodile market



26. ДНБ-ий өсөлтийг онуудаар харуулж буй хүснэгтийг ажиглаад, “Абсолют цэвэр өсөлт” болон “Өсөлтийн хурд”-ыг тооцоолоорой. /2 оноо/

Дараах томъёонуудаас сонгон бодолтыг хийгээрэй.

Y_n -Тухайн оны үзүүлэлт;

Y_{n-1} -Өмнөх оны үзүүлэлт

$$Y_n - Y_{n-1}; \quad \frac{Y_n}{Y_{n-1}}; \quad \frac{Y_n}{Y_{n-1}} \times 100\%; \quad \frac{Y_n}{Y_{n-1}} \times 100\% - 100\%;$$

Он	Үсгэн тэмдэглэгээ	ДНБ, тэрбум төгрөг	Абсолют цэвэр өсөлт	Өсөлтийн хурд /Хувиар/
2023	Y_{2023}	37,400,0	-	-
2024	Y_{2024}	44,800,0	a.....	b.....

A. a-7,400,0; b-1.197

B. a-7,400,0; b-119.7

C. a-119.7; b-7,400,0

D. a-7,400,0; b-19.7

E. a-19.7; b-7,400,0

Хүснэгтийг ажиглаад 27-28 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Монгол улсын гадаад худалдаа, сая ам.долл.				
№	Үзүүлэлт	2022	2023	2024
1	Нийт экспорт	4528.3	4645.9	6144.8
2	Нийт импорт	5186.5	5228.3	5259.7
3	Гадаад худалдааны тэнцэл	?	?	?
4	Ашиг/ алдагдал	?	?	?

27. Дээрх гурван оны гадаад худалдааны тэнцлийг зөв тодорхойлоорой. /1 оноо/

- A. 2022 онд /-658.2/, 2023 онд /-582.4/, 2024 онд /+885.1/
 B. 2022 онд /+658.2/, 2023 онд /+582.4/, 2024 онд /-885.1/
 C. 2022 онд /-658.2/, 2023 онд /+582.4/, 2024 онд /+885.1/
 D. 2022 онд /-9,714.8/, 2023 онд /-9,874.2/, 2024 онд /+11404.5/
 E. 2022 онд /+9,714.8/, 2023 онд /+9,874.2/, 2024 онд /-11404.5/

28. Дээрх гурван оны гадаад худалдааны ашиг болон алдагдлыг зөв тодорхойлоорой. /2 оноо/

- A. 2022 онд /ашиг/, 2023 онд /алдагдал/, 2024 онд /алдагдал/
 B. 2022 онд /алдагдал/, 2023 онд /алдагдал/, 2024 онд /ашиг/
 C. 2022 онд /алдагдал/, 2023 онд /ашиг/, 2024 онд /ашиг/
 D. 2022 онд /ашиг/, 2023 онд /ашиг/, 2024 онд /алдагдал/
 E. 2022 онд /ашиг/, 2023 онд /алдагдал/, 2024 онд /ашиг/

29. 1513 онд “Эзэн ван” (The Prince) зохиолыг бичсэнээр улс төрийн шинжлэх ухааны хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан бөгөөд орчин үеийн улс төрийн шинжлэх ухааныг үндэслэгч аль нь вэ? /1 оноо/

- A. Д.Истон B. Р.Даль C. Ж.Локк D. Б.Макиавелли E. Ш.Монтескье

30. 1990 оноос өмнөх төрийн бодлогод аль нь хамаарах вэ? /1 оноо/

- A. Бизнесийн тодорхой төлөвлөгөөгөөр нийгмээ болон өөрийгөө хөгжүүлэх
 B. Олон ургалч үзлийг хүлээн зөвшөөрч, олон намын тогтолцоог чухалчлах
 C. Үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд хэм хэмжээ тогтоох
 D. Сонгох, сонгогдох ардчилсан эрхээ бодитоор эдэлж хэрэгжүүлэх
 E. Хүний эрхийн түгээмэл зарчмуудыг амьдралдаа бодитойгоор хэрэгжүүлэх



31. Монгол улс хэдэн оноос бүх нийтийн, тэгш, шууд болон санал нууцаар хураах зарчмын үндсэн дээр сонгууль зохион байгуулах болсон бэ? /1 оноо/
 А. 1990 он В. 1911 он С. 1924 он D. 1951 он E. 1992 он

32. Дараах тохиолдлыг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй. /2 оноо/

Сонгуулийн мэдээ

2020 оны сонгуульд 800,000₮ болон түүнээс доош цалинтай иргэдийн 25%, 800,000₮-1,300,000₮ цалинтай иргэдийн 48%, 1,300,000₮-2,000,000₮ цалинтай иргэдийн 52%, 2,000,000₮-2,700,000₮ цалинтай иргэдийн 74%, 2,700,000₮-3,500,000₮ цалинтай иргэдийн 86%, 3,500,000₮ болон түүнээс дээш цалинтай иргэдийн 98% нь саналаа өгчээ.

Жич: Зохиомол тохиолдол тул тоон үзүүлэлтүүд нь тодорхой бүлгүүдийг илтгээгүй

Асуулт: 1,300,000₮ цалинтай буюу түүнээс доош цалинтай иргэдийн сонгуулийн идэвх оролцоог нэмэгдүүлэхийн тулд ямар арга хэмжээ авбал зохистой вэ?

- А. Өрхийн орлого багатай хүмүүсийн амьжиргааг төрийн бодлогоор дэмжих, цалинг нь нэмж өгөх
 В. Төрийн зүгээс бодлого боловсруулж санал өгөхгүй байгаа хүмүүсийг албадан саналыг өгүүлж ирцийг бүрдүүлэх
 С. Нам эвслээс нэр дэвшиж байгаа хүмүүсийн мөрийн хөтөлбөрийг маш сайн танилцуулах
 D. Орлого багатай хүмүүсийн амьжиргааг нийгмийн халамжийн хүрээнд зохицуулан дэмжиж сонгуулийн ирцийг бүрдүүлэх
 E. Улс төр болон сонгуульд идэвхтэй оролцуулах арга хэмжээ зохион байгуулах, түүний тухай ойлголттой болгох

33. Д. Истоны улс төрийн системийн ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /2 оноо/

а) Оролтод хамаарах шаардлага б) Үйлдэл в) Эргэх холбоо	1	Улс төрийн системийн дотроос эсвэл түүнийг хүрээлэн байгаа системүүдээс гарч буй тулгалтууд
	2	Улс төрийн системд хувьсан өөрчлөгдөж буй орчинд зохицох, шинэчлэх, өөрийгөө хадгалах бололцоог олгодог.
	3	Төрийн хэрэгжүүлэх албан ёсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэх
	4	Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт

- А. а3в2с4 В. а1в2с4 С. а2в4с3 D. а1в4с2 E. а1в3с4

34. Сонирхлын бүлгийн чиг үүргийн тухай ойлголтуудыг аль хэсгийн, ямар дараалал илэрхийлж байна вэ? /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Бүлгийн сонирхлыг нэг үзүүрт чиглүүлэх буюу нэгтгэхэд чиглэдэг.	Нийгэм дэх олон бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах.
2-р хэсэг	Иргэд төрийн хянаж, хариуцлага хүлээлгэж чаддаг хүмүүсийн нэгдэл	Төр, эдийн засаг, гэр бүлээс ангид орших нийгмийн хүрээ

- А. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б В. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
 С. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б D. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б
 E. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А



35. АНУ, Их Британи нар намын ямар тогтолцоотой вэ? /1 оноо/
 А. Хоёр намын тогтолцоо В. Нэг намын тогтолцоо С. Олон намын тогтолцоо
 D. Аядуу плюрал тогтолцоо E. Ноёрхогч намын тогтолцоо

36. Улс төрийн засаглалын үндсэн хэмжигдэхүүний тухай хүснэгтийг ажиглаад дутууг дараах өгөгдлүүдээс сонгоорой. /2 оноо/

Үндсэн хэмжигдэхүүн	Ямар нэгэн засгийн нөлөө, цар хүрээ, хэм хэмжээг тодорхойлох үзүүлэлт
	Тодорхой газар нутагт засаглалын үйл ажиллагаа үр ашигтай явагдана.
	Тухайн засаглалын оршин тогтнох хугацаа
	

- A. Нийгмийн институт болон удирдлагын тусламжтайгаар субъект өөрийн ноёрхлоо тогтоох
 B. Засаглалын субъект зорилгоо хэрэгжүүлэхийн тулд объектод үзүүлж буй арга хэрэгслийг хэлнэ.
 C. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль дүрмийн дагуу ардчилсан хэм хэмжээнд тулгуурладаг.
 D. Хичнээн тооны засаглал хэн нэгний буюу ямар нэгэн байгууллагын гарт төвлөрч байгааг илэрхийлдэг.
 E. Нийгэм дэх улс төрийн харилцаа засаглалыг хэрэгжүүлэх арга хэлбэр, төр нийгмийн хоорондын харилцаа
37. Милбрайтын боловсруулсан улс төрийн оролцооны ангилал аль нь вэ? /2 оноо/
 A. Дадал заншлын; Хууль зүйн В. Оролцогчид; Албатууд; Овгийнхон
 C. Конвенционал; Конвенционал бус D. Хууль тогоох; Гүйцэтгэх; Шүүх
 E. Ортодоксал оролцоо; Ортодоксал бус оролцоо; Улс төрийн гэмт хэрэг
38. Гуравдугаар үед эрх зүйн хэм хэмжээг тэргүүн зэрэгт тавьж байсан бүл аль вэ? /1 оноо/
 A. Англи-Америкийн эрх зүйн бүл В. Холимог болон хосолмол эрх зүйн бүл
 C. Заншлын эрх зүйн бүл D. Ром-Германы буюу эх газрын эрх зүйн бүл
 E. Шашны эрх зүйн бүл
39. Эрх зүйн хэм хэмжээний дотоод логик бүтэц аль нь вэ? /1 оноо/
 A. Гипотез; Диспозици; Санкц
 B. Албан хэм хэмжээ; Албан бус хэм хэмжээ; Хэм хэмжээ
 C. Материаллаг эрх зүй; Процессын эрх зүй; Шатлалын онол
 D. Хэм хэмжээний заалт; Хэм хэмжээний институт; Эрх зүйн бүрдэл
 E. Эрх зүйн харилцааны объект; Хууль зүйн факт; Эрх зүйн харилцааны агуулга
40. 2025 оны 5-р сарын 25-ны өдөр болсон хэрэгт иргэн С 2025 оны 6-р сарын 7-ны өдөр гомдол захиргааны байгууллагад гаргасан нь хугацаа хэтэрсэнд тооцогдох уу? /2 оноо/
 A. 5-р сарын 25-ны өдөр болсон хэргийг 6-р сарын 7-нд захиргааны байгууллагад гомдол гаргасан тул хугацаа хэтэрсэнд тооцох үндэслэлтэй.
 B. Эрх нь зөрчигдсөнөөс хойш 14 хоногийн дотор гомдол гаргах ёстой байдаг тул захиргааны байгууллага гаргасан гомдлыг хугацаа хэтэрсэнд тооцох үндэслэлгүй.
 C. 5-р сарын 25-ны өдөр болсон хэргийг 6-р сарын 7-нд захиргааны байгууллагад иргэн С хэргийн гэрчтэй хамт гомдол гаргаагүй тул хугацаа хэтэрсэнд тооцох үндэслэлтэй.
 D. 5-р сарын 25-ны өдөр болсон хэргийг 6-р сарын 7-нд захиргааны байгууллагад гуравдагч этгээдтэй хамт гомдол гаргаагүй тул хугацаа хэтэрсэнд тооцох үндэслэлтэй.
 E. Эрх нь зөрчигдсөнөөс хойш 30 хоногийн дотор захиргааны байгууллагад гомдол гаргасан тул хугацаа хэтэрсэнд тооцох үндэслэлгүй.



41. Өмчлөх эрх үүсэх хуульд заасан үндэслэл аль вэ? /1 оноо/
А. Арилжааны гэрээ В. Бэлэглэлийн гэрээ С. Эд хөрөнгийг хувьчлан авах
D. Худалдах, худалдан авах гэрээ E. Зээлээр худалдах, худалдан авах гэрээ

42-45 дугаар даалгаврыг доорх тохиолдлыг уншиж гүйцэтгээрэй.

ХҮНДХЭН ӨДРҮҮД

Иргэн О 2023/09/28-нд нэгэн сургуульд багшаар ажилд орохоор ажил олгогч Г-тэй уулзаж ярилцлагад орсон. Харин ажил олгогч Г нь О-г ярилцлагад орсны дараа ажил даалгаж өгсөн байна. Ажилч олгогч Г болон О хоёр 2023/10/01-ны өдөр хөдөлмөрийн гэрээгээ байгуулж гарын үсэг зуралцсан. 2025/02/27 өдрөөс ажил олгогч Г нь О-д ажлын байрны дарамт удаа дараа үзүүлсэн. О нь жирэмсэн байсан тул энэхүү ажлын байрны дарамтаас болж бие нь өвдсөн. Тиймээс ажлаасаа гарахаар шийджээ.

42. Ажил олгогч Г нь ажилтан О-г ярилцлагад орсны дараа ажил даалгаж болох уу? /2 оноо/
А. Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй бол ажилтнаас ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болохгүй.
В. Ажил олгогч Г нь үндсэн хуулийн 16-р зүйлийг үндэслэн ажилтан О-д ажил даалгаж болно.
С. Иргэн О нь багшаар ажилд орсон тул хөдөлмөрийн гэрээ байгуулах шаардлагагүй тул, ажил үүргээ гүйцэтгэж болно.
D. Ажил олгогч Г нь хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийг үндэслэн ажилтан О-д ажил даалгаж болно.
E. Хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ч гэсэн ажилтнаас ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болно.
43. Ажил олгогч Г нь сахилгын зөрчил гаргасан бол түүнд хэдэн сарын дотор шийтгэл ноогдуулах ёстой вэ? /2 оноо/
А. Зөрчил гаргаснаас хойш 9 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 4 сарын дотор
В. Зөрчил гаргаснаас хойш 7 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 2 сарын дотор
С. Зөрчил гаргаснаас хойш 6 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 1 сарын дотор
D. Зөрчил гаргаснаас хойш 8 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 3 сарын дотор
E. Зөрчил гаргаснаас хойш 10 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 5 сарын дотор
44. Иргэн О нь ажлаас гарахдаа доорх хэлбэрээс алийг нь сонгох вэ? /1 оноо/
А. Өргөдөл В. Нэхэмжлэл С. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр
D. Гомдол E. Захиргааны акт
45. Иргэн О жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг цалингийн хэдэн хувиар тооцон нийгмийн даатгалын сангаас авах ёстой вэ? /1 оноо/
А. 17 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцно.
В. 16 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцно.
С. 12 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцно.
D. 12 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцно.
E. 16 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцно.



46. Даатгуулагч Сувд нь 55 настай, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 27 жил төлсөн бол тэтгэврийн нэмэгдэл нь хэдэн хувиар нэмэгдэхийг тооцоолно уу. /2 оноо/
 A. 7% B. 40.5% C. 13.5% D. 27% E. 10.5%
47. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 12 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо. Тэгвэл өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ хэд болохыг тооцоорой. /2 оноо/
 A. 560,000 төгрөг B. 495,000 төгрөг C. 330,000 төгрөг
 D. 660,000 төгрөг E. 462,000 төгрөг
48. Олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэрийг гэнэ. /1 оноо/
 A. Де-юре B. Де-факто C. Императив D. Диспозитив E. Дипломат
49. Олон улсын харилцааны улс бус оролцогчдод аль нь хамаарах вэ? /1 оноо/
 A. BBC агентлаг B. Бага улс C. Их гүрэн D. Дунд улс E. Бүрэн эрхт улс
50. Нэгдсэн Үндэсний Байгууллага гэж нэрлэх болсон шалтгаан аль нь вэ? /1 оноо/
 A. Боолуудыг чөлөөлсөн цаг үеийг хүндэтгэж
 B. АНУ-ын тусгаар тогтнолын тунхаглалыг хүндэтгэж
 C. АНУ-ын ерөнхийлөгч Д.Рузвельтийн дурсгалыг хүндэтгэж
 D. Сирусийн бортогод дурдсан боолуудыг чөлөөлснийг хүндэтгэж
 E. “Магна Харта” хэмээх тунхаг бичиг баталгаажуулсан Жон хааны дурсгалыг хүндэтгэж
51. Бүс нутгийн түвшний байгууллагад аль нь хамаарах вэ? /1 оноо/
 A. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн B. ОУ-ын гаалийн шүүх C. НҮБ
 D. Исламын улсуудын чуулга уулзалт E. АПЕК
52. Дараах өгөгдлөөс хоёр хөрштэйгээ харилцах чиглэлүүдийг олоорой. /2 оноо/
 Өгөгдөл: /1-улс төрийн, 2-эдийн засгийн, 3-соёлын, 4-боловсролын, 5-хамтын ажиллагааны, 6-хүмүүнлэгийн /
 A. 1,2,4,5,6 B. 1,2,3,4,5 C. 2,3,4,5,6 D. 1,2,3,4,6 E. 1,2,3,5,6
53. Монгол улс нь олон улс гүрэнтэй хамтран ажиллах гадаад харилцааг олон хэлбэрээр явуулах нь ОУ-ын хамтын нийгэмлэг дэх оролцооны аль зарчимд хамаарах вэ? /1 оноо/
 A. Олон тулгуурт байх B. Прагматик байх C. Тэнцвэртэй байх
 D. Үндэсний эрх ашигт нийцсэн байх E. Найрсаг байх
54. Дараах өгөгдлийг ажиглаад 2018 оны байдлаар Монгол улстай “иж бүрэн түншлэлтэй” улсуудыг олоорой. /2 оноо/
 Өгөгдөл: /1-Турк, 2-БНХАУ, 3-Австрали, 4-БНСУ, 5-Герман, 6-Энэтхэг/
 A. 2,3,5 B. 1,3,6 C. 1,4,5 D. 2,5,6 E. 1,3,5



55. Монгол улсын “Гуравдагч хөрш” орнуудын хамтын үйл ажиллагаа зөв харгалзуулна уу.

/2 оноо/

а) ТИКА төсөл б) Мянганы сорилтын сан с) Хааны эрэлд	1	АНУ уг гэрээгээр 350 сая ам долларын буцалтгүй тусламжийг олгожээ.
	2	Турк улс уг төслийн хүрээнд 1994 оноос 30 сая ам долларын тусламж үзүүлжээ.
	3	2003 оноос АНУ-тай хамтарсан уг цэргийн сургуулилалтыг хэрэгжүүлж эхэлжээ.

A. a3b1c2

B. a2b3c1

C. a1b3c2

D. a3b2c1

E. a2b1c3

56. Жозеф Самуэль Най, Роберт Коэхэнтэй хамтран 1977 онд олон улсын харилцааны неолиберал онолын чиглэлээр “Хүч чадавх ба харилцан хамаарал” гэсэн бүтээлээ туурвисан. Энэхүү бүтээлд хамаарах үзэл санааг ялгаарай.

/2 оноо/

1. Клинтонь засаглалын үед түүний ухаалаг хүчний бодлогыг дэмжсэн
2. ОХУ-д зөөлөн хүчний бодлогыг дэвшүүлж, хүлээн зөвшөөрүүлсэн
3. Эдийн засгийн дипломат харилцааг тодорхойлж тайлбарласан
4. Гадаад худалдааны протекционист бодлогыг дэвшүүлсэн

A. 2, 3

B. 1, 3

C. 2, 4

D. 3, 4

E. 1, 2

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

/5 оноо/

а) Меркантилизм б) Физиократизм с) Сонгодог эдийн засгийн ухаан д) Шинэ сонгодог онол е) Монетаризм	1	Цэвэр буюу төгс өрсөлдөөн бол тогтвортой байдлын өндөр зэргийг хангана
	2	Худалдаа арилжаа нь ямарч баялагийг бүтээдэггүй, тэнд ашиг бий болдоггүй гэж нотлосон
	3	Төрийн зохицуулалтаар эдийн засгийн үр өгөөжтэй хөгжлийг хангаж болно.
	4	Нэмүү өртөг нь гүйлгээний хүрээнд бий болдоггүй энэ нь хөдөлмөрийн бус орлого буюу мөлжлөгийн үр дүн гэж үзсэн.
	5	XVII зууны дунд үед хөгжлийнхөө дээд цэгт хүрсэн бөгөөд гол төлөөлөгчид нь У.Петти, Б.Кольберг
	6	Хүн болгоны ашиг хонжоо хайсан үйл ажиллагаа нь эцсийн дүндээ нийгмийн баялагийг бүтээдэг



2.2. Улс төрийн намуудын ангилалуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

а) Ангийн мөн чанараар нь б) Улс төрийн үйл ажиллагааны арга хэрэгслээр нь в) Нийгмийн байгуулалд хандах хандлагаар нь д) Улс төрийн системд эзлэх байр сууриар нь е) Төрийн байгууламжид хандах хандлагаар нь	1	Ноёрхогч, сөрөг хүчин, зүүн, төв, баруун
	2	Ажилчны, хөрөнгөтний, дундаж ангийн, тариачны, овгийн, үндэстний, сэхээтний
	3	Парламентийн болон парламентийн гадна үйл ажиллагаа явуулагч
	4	Нэгдмэл, холбооны, салан тусгаарлагч
	5	Хувьсгалт, реформист, либерал, консерватив

2.3. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

а) Тунхаглал б) Пакт в) Протокол д) Гэрээ е) Хүсэлт	1	Өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт
	2	Хоёр ба түүнээс дээш тооны этгээдүүд үр дагаврыг бий болгох байдлаар харилцан тохиролцож хийсэн бичвэр
	3	Хуульчлан дагаж мөрдөх албагүй зөвлөмж, уриалгын шинжтэй баримт бичиг
	4	Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт бичиг
	5	Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр.
	6	Хоёр болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ

2.4. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

а) Марксист онол б) Неореалист онол в) Неомарксист онол д) Либерал онол е) Реалист онол	1	ОУХ-ны бүрэн эрхт субъектүүд нь бүрэн эрхт улс, үндэстэн дамнасан корпорациуд, ЗГ-ын бус байгууллагууд байдаг
	2	ОУХ нь нийгмийн тодорхой анги бүлэглэлүүдийн харилцааны үр дүн юм.
	3	ОУХ-ны тоглогчид нь зөвхөн үндэсний бүрэн эрхт улсууд байдаг
	4	ОУХ-ны тоглогчид нь бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо, эвсэл байна.
	5	ОУХ-ны үндсэн тоглогчид нь нийгмийн ангиуд байна.
	6	ОУХ-ны үндсэн тоглогчид нь бүрэн эрхт улс дангаар биш түүнээс ОУБ, үндэсний болон бусад нийгэмлэг, хувь хүмүүс байж болно

